МЭДЭЭ · 2024 оны 2-р сарын 20

БАЯНЗҮРХ ДҮҮРЭГТ ГАРСАН ГАЛЫН УЛМААС 228 ИРГЭН, 15 АЖ АХУЙН НЭГЖ ЭД ХӨРӨНГӨӨРӨӨ ХОХИРЧЭЭ



Энэ оны 1 дүгээр сард Баянзүрх дүүргийн 26 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах "Дүнжингарав" худалдааны төвийн замд гарсан галын хэрэгт ажлын хэсэг байгуулсан талаар өмнө нь мэдээлсэн. /энд дарж үзнэ үү/

Галын улмаас Онцгой байдлын 3 албан хаагч, явган болон автомашинаар зорчиж явсан 4 иргэн нас барж, 9 хүн хүнд, хөнгөн гэмтсэн байна. Мөн 35 тээврийн хэрэгсэл, 3 барилга байгууламж шатаж, 228 иргэн, 15 аж ахуйн нэгж байгууллагын эд хөрөнгөд хохирол учирчээ.

Ажлын хэсгээс 200 орчим иргэн, аж ахуйн нэгжийг хохирогч, иргэний нэхэмжлэгчээр тогтоон мэдүүлэг авч, галын шалтгаан нөхцөл, хохирлын хэмжээг тогтоохоор шаардлагатай мөрдөн шалгах ажиллагааг явуулж байна.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1460